



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2010 оны 10 сарын 27 өдөр

Дугаар 279

Улаанбаатар хот

Г “Их түншлэл ББСБ” ХХК-ийн Г
банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх
тусгай зөвшөөрлийг сунгах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 6.2.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. ”Их түншлэл ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2010 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн 3 жилийн хугацаагаар сунгасугай.

2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад сунгалтын талаарх тэмдэглэгээг 2010 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор хийлгэхийг ”Их түншлэл ББСБ” ХХК /С.Батчимэг/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН